



Улсын Их Хурал (УИХ)-аас 2024 оны 8-р сарын 30-нд 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг баталсан. Төсвийн модотголыг дагалдан Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан зардлын дүнгээр татварын хөнгөлөлт эдлүүлэхээр болж байна. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Органик бүтээгдэхүүний тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хуулиуд батлагдсантай холбогдуулан 2024 онд ААНОАТ, Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), Онцгой албан татвар, Гаалийн тариф, гаалийн татварын тухай зэрэг хуулиудад зарим нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

Түүнчлэн Засгийн газраас 2024 оны 8-р сарын 30-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барьсныг УИХ одоо хэлэлцэж байгаа билээ. Төсвийн төслийг дагалдуулан зарим татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьсан байна.

Үгээр та бүхэнд 2024 онд батлагдсан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд болон 2025 оны төсвийг дагалдан УИХ-аар хэлэлцэгдэж буй татварын хуулийн өөрчлөлтийн төслүүдийн талаар товч мэдээллийг танилцуулж байна.

1. ААНОАТ-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд


Нэмэлт өөрчлөлт орсон огноо	Агуулга
2024.1.17	Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчийн орлогыг эхний таван жилд 100 хувиар, дараагийн таван жилд 50 хувиар татвараас хөнгөлнө.
2024.4.19	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эцсийн эзэмшигч нь хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ бэлэглэх, өв залгамжлалаар өвлүүлэх хэлбэрээр газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн бусдад шилжүүлсэн тохиолдолд 30 хувиар бусад тохиолдолд 10 хувиар татвар ногдуулахаар заасан. (Энэхүү өөрчлөлт нь Баялгийн сангийн тухай хуулийг дагаж хийгдсэн ба Баялгийн сангийн тухай хуулийн талаар бэлтгэсэн манай татвар, хуулийн мэдээллийг энд дарж үзнэ үү.)
2024.05.16	Соёлын бүтээл үйлдвэрлэгчийн орлогыг эхний 3 жилд 90 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар татвараас хөнгөлнө.
2024.06.05	Асрамж, халамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах байрыг шинээр барих, тохижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөхөд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандивыг хасагдах бусад зардалд нэмж оруулсан.
2024.06.05	Олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулсан, засварласан зардал болон ойр орчмын гудамж талбайд хяналтын камер худалдан авч суурилуулахтай шууд холбогдон гарсан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн татвар ногдох орлогоос хасаж тооцно.
2024.06.05	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн борлуулалтын орлогыг эхний 5 жилд татвараас хөнгөлөхөөр заасан.
2024.08.30	Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг татвараас хасаж хөнгөлнө: <ul style="list-style-type: none"> ✓ ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах; ✓ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, эдгээр иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах; ✓ соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сан болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах; ✓ нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих; ✓ давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах; ✓ спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг; ✓ Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын болон дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаа оюутанд олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг; ✓ их, дээд сургууль, ШУ-ны академид судалгаа, шинжилгээнд олгосон тэтгэлэг; ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа; ✓ Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа. ✓ Бусад нөхөн сэргээх зардал хамаарна.



- 2035 оны 1 сарын 1-ний өдрийг хүртэл энэхүү хөнгөлөлтийг эдлүүлнэ.
- Татварын хөнгөлөлтийн дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувиас хэтрэхгүй байна.
- Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн яам баталж, хяналт тавина.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.



1. ААНОАТ-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд (үргэлжлэл)

Нэмэлт өөрчлөлт орсон огноо	Агуулга
2024.08. 30	<p>Өмнө дурдсан татварын хөнгөлөлтийг нэвтрүүлснээр дараах зардлуудыг татвар ногдох орлогоос хасагдуулахгүй болсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Өөрийн захиалгаар мэргэжилтэн бэлтгүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэг; Хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэний үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив; Спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих, олон улсын спортын холбооны стандартад нийцсэн, олимп, тив дэлхийн тэмцээн, наадам зохион байгуулах, спортын барилга байгууламжийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд өгсөн 100 сая хүртэлх төгрөгийн хандив; Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд өгсөн хандив, хөрөнгө; Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор өгсөн хандив; Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив. Нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний үйл ажиллагааны зардал.

2. НӨАТ-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд


Нэмэлт өөрчлөлт орсон огноо	Агуулга
2024.06. 05	<ul style="list-style-type: none"> Малчдын хоршоо, малчны борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөвөрийг НӨАТ-аас чөлөөлсөн.

3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

Нэмэлт өөрчлөлт орсон огноо	Агуулга
2024.05.16	МУ-д бүтээх боломжгүй том хэмжээний уран баримал, урлагийн бүтээлийг болон гадаад улсаас МУ-д авчрах соёлын өвийн хуулбарыг татвараас чөлөөлсөн.
2024.06.05	Шинэ Зуунмод хотын хөгжлийн төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулсан барилгын материал, тоног төхөөрөмж болон оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн татвараас чөлөөлсөн.

4. Гаалийн тариф, НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль

Нэмэлт өөрчлөлт орсон огноо	Агуулга
2024.06.05	<p>Мөн түүнчлэн дараах чиглэлд нийцсэн техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төслийн хүрээнд импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн гаалийн болон НӨАТ албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргахаар болсон:</p> <ul style="list-style-type: none"> Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээ Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан техник, эдийн засгийн үндэслэл бүхий барилгажилтын төслүүд Олимп, тив дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийн төслүүд



5. Онцгой албан татварын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

Онцгой албан татвар ногдох бараа, үйл ажиллагаанд чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усыг 2024 оны 6 сарын 5-нд нэмж оруулсан. (Үүнд үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах байгалийн гаралтай өтгөрүүлсэн шүүс, нунтаг баяжмал хамаарахгүй.)

Чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжийг 1 литр тутмаар онцгой албан татвар ногдуулна.

Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ			
		2027	2028	2029 ба түүнээс хойш	
100 мл-т агуулагдах чихэр, чихэр орлуулагч	0-5 гр	1 литр	0	0	0
	5 гр-аас дээш	1 литр	₮ 500	₮ 525	₮ 550

Энэхүү өөрчлөлт нь 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс үйлчилнэ

6. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төслийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл хувь, хэмжээг **10 жил хүртэлх хугацаанд 0.6 хүртэлх хувиар бууруулан** тогтоох боломжтой болсон.

Мөн Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу баригдсан нийтийн номын сан, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, боловсрол, соёлын болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай, олон улсын стандартад нийцсэн барилга, байгууламжид ногдох үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглалтад оруулах шийдвэр гарснаас хойш **эхний 5 жилийн хугацаанд чөлөөлнө**. Үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн яамны саналыг үндэслэн Засгийн газар батална.

7. 2025 оны “Төсвийн тухай хууль”-ийг дагалдан татварын хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн төсөл

Бүсийн хөгжлийг дэмжих чиглэлээр

Засгийн газраас тогтоосон бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих зорилгоор ААНОАТ-ын хуульд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар хуулийн төслийг бэлтгэсэн байна:

- Засгийн газраас тогтоосон бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үйл ажиллагаанаас олох орлогод ногдох албан татварыг эхний 5 жилд 90 хувь хөнгөлөхөөр заасан.

Үнэ шилжилтийн тайлагналтай холбоотойгоор

Улс бүрээр үнэ шилжилтийн тайлан гаргах үүрэгтэй үндэстэн дамнанас корпорацын орлогын босгыг ААНОАТ-ын хуульд 1.7 их наяд төгрөг хэмээн тусгасан нь ханшийн зөрүүний улмаас энэ дүн еврогоор илэрхийлэхэд олон улсын стандартаас зөрүүтэй болж байгаатай холбоотой 1.7 их наяд төгрөгийг 750 сая евро гэж өөрчлөхөөр хуулийн төслийг бэлтгэсэн байна.



Холбоо барих

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирийн Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhसानаа.erdene-ochr@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Та дээрх болон бусад асуудлаар татварын зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.